



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/240/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2-10
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4-5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7-8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8-10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13-14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14-15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ТҮМЭНБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			<i>Төгрөгөөр</i>
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	96,796,704.85	115,454,278.40
33	АВЛАГА	0.00	5,749,023.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	5,749,023.00
35	БАРАА МАТЕРИАЛ	96,796,704.85	109,705,255.40
351	Түүхий эд материал	8,630,691.33	8,086,891.33
35110	Тусгай зориулалттай материал	5,490,246.04	5,008,746.04
35130	Эм боох материал	3,140,445.29	3,078,145.29
354	Хангамжийн материал	88,166,013.52	101,618,364.07
35410	Бичиг хэргийн материал	3,092,770.54	2,205,216.00
35420	Аж ахуйн материал	7,514,400.00	7,264,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	314,500.00	642,500.00
35440	Түлш, шатах тослох материал	7,894,101.02	4,084,943.08
35450	Барилгын засварын материал	3,696,114.29	4,308,090.00
35470	Бусад хангамжийн материал	65,654,127.67	83,113,214.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,403,994,535.52	1,340,333,961.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,403,994,535.52	1,340,333,961.74
392	Биет хөрөнгө	1,352,494,535.52	1,288,833,961.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,262,749,232.20	1,262,749,232.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	-65,201,718.00	-97,734,651.65
39203	Авто-тээврийн хэрэгсэл	116,357,256.76	116,357,256.76
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,147,758.29	-76,022,789.23
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	742,866,584.26	747,866,584.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-661,238,302.88	-686,632,981.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,189,005.00	37,043,905.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,079,763.53	-14,792,594.27
393	Биет бус хөрөнгө	51,500,000.00	51,500,000.00
39301	Програм хангамж	285,200.00	285,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-285,200.00	-285,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	51,500,000.00	51,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,500,791,240.37	1,455,788,240.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	5,749,023.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	5,749,023.00
413	Өглөг	0.00	5,749,023.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	5,749,023.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,500,791,240.37	1,450,039,217.14
51	Засгийн газрын хувь оролцоо	1,500,791,240.37	1,450,039,217.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	244,694,006.84	244,694,006.84
51101	Өмч: - төрийн	244,694,006.84	244,694,006.84
512	Хуримтлагдсан үр дүн	1,197,205,929.68	1,146,453,906.45
51210	Өмнөх үеийн үр дүн	1,141,733,731.04	1,197,205,929.68
51220	Тайлант үеийн үр дүн	55,472,198.64	-50,752,023.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58,891,303.85	58,891,303.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,500,791,240.37	1,455,788,240.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>Төгрөгөөр</i>			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,155,491,696.76	1,069,151,552.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,285,536.76	41,582,852.50
120	Нийтлэг татварын бус орлого	95,285,536.76	41,582,852.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	95,285,536.76	41,582,852.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,495,820.00	35,002,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	61,789,716.76	6,580,152.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,060,206,160.00	1,027,568,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,040,249,000.00	1,023,810,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,040,249,000.00	1,023,810,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,957,160.00	3,758,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,457,160.00	2,880,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	878,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,100,019,498.12	1,119,903,575.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,100,019,498.12	1,119,903,575.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,031,055,177.48	1,050,574,208.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	642,110,605.26	628,262,735.00
210101	Үндсэн цалин	499,870,830.00	500,503,209.00
210102	Нэмэгдэл	109,921,475.26	108,676,176.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,237,493.00	19,083,350.00
210104	Урамшуулал	12,080,807.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,061,902.10	84,230,112.70
210201	Тэтгэврийн даатгал	56,196,941.39	58,675,403.84
210202	Тэтгэмжийн даатгал	6,601,661.66	6,505,225.45
210203	ҮОМШ өвчний даатгал	5,136,885.12	5,079,861.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,284,227.54	1,269,965.10
210205	Эрүүл мэндийн даатгал	12,842,186.39	12,699,656.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,120,411.00	70,210,190.00
210301	Гэрэл цахилгаан	6,780,971.00	6,857,901.00
210302	Түлш, халаалт	61,413,736.00	60,162,465.00
210303	Цэвэр, бохир ус	1,925,704.00	3,189,824.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,679,439.45	61,429,049.24
210401	Бичиг хэрэг	9,105,849.57	11,125,557.54
210402	Тээвэр, шатахуун	27,137,163.88	34,399,447.94
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,769,096.00	6,625,222.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,427,330.00	9,038,821.76
2105	Норматив зардал	9,594,330.51	9,023,849.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,030,089.86	3,996,860.00
210502	Хоол, Хүнс	2,564,240.65	5,026,989.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,138,799.09	52,096,381.71
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	19,431,763.38	42,855,187.42
210604	Урсгал засвар	14,707,035.71	9,241,194.29
2107	Томилолт, зочны зардал	24,004,500.00	29,000,200.00
210702	Дотоод албан томилолт	24,004,500.00	29,000,200.00



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,093,976.10	44,924,217.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,700,346.00	40,520,675.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	119,600.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	278,655.00	532,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,436.00	263,022.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,666,000.00	1,361,000.00
210807	Газрын төлбөр	232,040.00	217,640.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	750,899.10	1,908,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,251,213.97	71,397,473.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,100,000.00	882,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	83,151,213.97	70,515,473.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,964,320.64	69,329,367.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,625,220.64	32,076,667.30
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	20,625,220.64	32,076,667.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,843,280.00	2,250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,843,280.00	2,250,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,375,820.00	35,002,700.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,375,820.00	35,002,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	120,000.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	55,472,198.64	-50,752,023.23
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	55,472,198.64	-50,752,023.23



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,093,701,980.00	1,062,571,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,495,820.00	35,002,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,495,820.00	35,002,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,495,820.00	35,002,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,495,820.00	35,002,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,060,206,160.00	1,027,568,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,040,249,000.00	1,023,810,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,040,249,000.00	1,023,810,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,957,160.00	3,758,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,457,160.00	2,880,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	878,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,065,600,237.00	1,055,716,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,065,600,237.00	1,055,716,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	995,279,926.36	983,037,132.70
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	642,110,605.26	628,262,735.00
210101	Үндсэн цалин	500,385,698.00	500,503,209.00
210102	Нэмэгдэл	109,494,807.26	108,676,176.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	20,149,293.00	19,083,350.00
210104	Урамшуулал	12,080,807.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,061,902.10	84,230,112.70
210201	Тэтгэврийн даатгал	56,196,941.39	58,675,406.84
210202	Тэтгэмжийн даатгал	6,601,661.66	6,505,225.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,136,880.12	5,079,861.59
210204	Ажилгүйдлийн даатгал	1,284,227.54	1,269,965.10
210205	Эрүүл мэндийн даатгал	12,842,191.39	12,699,653.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,120,411.00	70,210,190.00
210301	Гэрэл, цахилгаан	6,780,971.00	6,857,901.00
210302	Түлш, халаалт	61,413,736.00	60,162,465.00
210303	Цэвэр, бохир ус	1,925,704.00	3,189,824.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,238,221.00	56,228,338.00
210401	Бичиг хэрэг	9,926,400.00	10,827,863.00
210402	Тээвэр, шатахуун	32,894,565.00	33,385,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,812,096.00	6,625,222.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,365,160.00	5,150,163.00
2105	Норматив зардал	21,353,160.00	23,585,060.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,103,190.00	18,084,380.00
210502	Хоол, хүнс	2,249,970.00	5,500,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,152,800.00	45,082,230.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	42,400,000.00	33,999,740.00
210604	Урсгал засвар	13,752,800.00	11,082,490.00
2107	Томилолт, зочны зардал	24,004,500.00	29,000,200.00
210702	Дотоод албан томилолт	24,004,500.00	29,000,200.00



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,138,327.00	45,411,267.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,495,996.00	40,520,675.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	119,600.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	278,655.00	532,680.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,436.00	263,022.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,666,000.00	1,757,000.00
210807	Газрын төлбөр	232,040.00	217,640.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,999,600.00	1,999,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,100,000.00	1,027,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,100,000.00	1,027,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,320,310.64	72,679,367.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,625,220.64	32,076,667.30
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	20,625,220.64	32,076,667.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,199,270.00	5,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,199,270.00	5,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,375,820.00	35,002,700.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,375,820.00	35,002,700.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	120,000.00	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,101,743.00	6,854,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,101,743.00	6,854,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,101,743.00	6,854,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,101,743.00	6,854,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,101,743.00	6,854,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-28,101,743.00	-6,854,900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,023,810,700.00	1,023,810,700.00	0.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,023,810,700.00	1,023,810,700.00	0.00	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,018,210,700.00	986,134,032.70	32,076,667.30	96.8
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	637,661,400.00	628,262,735.00	9,398,665.00	98.5
210101	Үндсэн цалин	507,922,300.00	500,503,209.00	7,419,091.00	98.5
210102	Нэмэгдэл	109,169,100.00	108,676,176.00	492,924.00	99.5
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	20,570,000.00	19,083,350.00	1,486,650.00	92.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,084,200.00	84,230,112.70	1,854,087.30	97.8



210201	Тэтгэврийн даатгал	60,577,800.00	58,675,406.84	1,902,393.16	96.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,376,600.00	6,505,225.79	-128,625.79	102.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,101,300.00	5,079,861.59	21,438.41	99.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,275,300.00	1,269,965.10	5,334.90	99.6
210205	Эрүүл мэндийн даатгал	12,753,200.00	12,699,653.38	53,546.62	99.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,752,900.00	70,210,190.00	15,542,710.00	81.9
210301	Гэрэл, цахилгаан	8,062,000.00	6,857,901.00	1,204,099.00	85.1
210302	Түлш, халаалт	73,882,100.00	60,162,465.00	13,719,635.00	81.4
210303	Цэвэр, бохир ус	3,808,800.00	3,189,824.00	618,976.00	83.7
2104	Хангамж, бараа материалын зардал	56,935,800.00	55,728,338.00	1,207,462.00	97.9
210401	Бичиг хэрэг	10,828,800.00	10,827,863.00	937.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	32,894,600.00	32,885,090.00	9,510.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,812,100.00	6,625,222.00	1,186,878.00	84.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	240,000.00	10,000.00	96.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,150,300.00	5,150,163.00	137.00	100.0
2105	Норматив зардал	20,334,800.00	20,327,060.00	7,740.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,084,800.00	18,084,380.00	420.00	100.0
210502	Хоол, хүнс	2,250,000.00	2,242,680.00	7,320.00	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	51,483,100.00	51,482,130.00	970.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	34,000,000.00	33,999,740.00	260.00	100.0
210604	Урсгал засвар	12,483,100.00	12,482,390.00	710.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	31,021,600.00	29,000,200.00	2,021,400.00	93.5
210702	Дотоод албан томилолт	31,021,600.00	29,000,200.00	2,021,400.00	93.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,831,500.00	45,866,267.00	1,965,233.00	95.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,997,400.00	40,975,675.00	21,725.00	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,663,400.00	0.00	1,663,400.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	550,000.00	532,680.00	17,320.00	96.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	348,000.00	263,022.00	84,978.00	75.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	134,000.00	121,000.00	13,000.00	90.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,757,000.00	1,757,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	381,700.00	217,640.00	164,060.00	57.0

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	1,999,250.00	750.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,105,400.00	1,027,000.00	78,400.00	92.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,105,400.00	1,027,000.00	78,400.00	92.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,600,000.00	37,676,667.30	-32,076,667.30	672.8
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	32,076,667.30	-32,076,667.30	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	32,076,667.30	-32,076,667.30	
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,600,000.00	5,600,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,600,000.00	5,600,000.00	0.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,023,810,700.00	1,023,810,700.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,023,810,700.00	1,023,810,700.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	53.00	53.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,758,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,758,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,758,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		500,000.00
210402	Тээвэр, шатахуун		500,000.00
2105	Норматив зардал		3,258,000.00
210502	Хоол, хүнс		3,258,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,758,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,758,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,880,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		878,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газартай холбоотой төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, анхан шатны баримтыг бүрдэл хяналтыг сайжруулах, Шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд мэдээлэх мэдээллийг хугацаанд нь бүрэн үнэн зөв мэдээлж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мэргэжлийн хяналтын газар нь нутгийн захиргааны байгууллагаас гаргасан хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах талаар зохион байгуулж байгаа ажилд дүн шинжилгээ хийж, үр нөлөөг нь сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцээгүй бөгөөд шинэчлэн боловсруулаагүй байна.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 1,100.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянасан бөгөөд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 96.8 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 109.7 сая төгрөг болж 12.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бусад хангамжийн материал дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй болбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 1,404.0 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 1,340.3 сая төгрөг болж буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Мөнгөн хөрөнгийн тухайд нийт орлого өмнөх онд 1,093.7 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 1,062.6 сая төгрөг болж 31.1 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оноос бага төсөв хуваарилагдсан болон урсгал үйл ажиллагааны санхүүжилт буурсан зэргээс шалтгаалсан байна.

Өр авлагын тухайд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 5.7 сая төгрөг, хувь хүний орлогын албан татварын авлага 5.7 сая төгрөг үүссэн байна. Өр авлага үүссэн шалтгаан нь төрийн сангийн мэргэжилтэн данс андуурч шилжүүлэг хийснээс шалтгаалсан байна.

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулгад тайлант онд үүссэн өр, авлага, үндсэн хөрөнгө, бараа материал болон мөнгөн хөрөнгө, төсвийн гүйцэтгэлийн талаарх бүхий л мэдээллийг бүрэн тусгасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2021 оны төсвийн төслийг 1,750.0 сая төгрөгөөр төлөвлөн боловсруулж төсвийн саналаа Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлсэн байна. Хүргүүлсэн төсвийн төслийг хянаж үзээд 992.4 сая төгрөгөөр төсвийг анх баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 992.4 сая төгрөгийн төсөв баталснаас 892.4 сая төгрөгийг улсын

төсвөөс 30.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна. Тайлант онд тодотголоор нийт 31.4 сая төгрөгийн төсвийг нэмж баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,023.8 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 35.0 сая төгрөг, нийт 1,058.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, бараа үйлчилгээний зардалд 1,018.2 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 5.6 сая төгрөгийг зарцуулж засгийн газрын дотоод шилжүүлгээр 32.1 сая төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 35.0 сая төгрөгийг тус тус улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.9 сая төгрөгийг, дээд шатны төсвийн захирагчаас 0.9 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус хуваарилсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас бараа үйлчилгээний зардалд 3.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар асуудлыг онцолсон зүйл байхгүй болно.

Бусад асуудлын тухайд

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага:

- Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
- Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.
- Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

3.8 Аудитын гол асуудал

1. Урсгал засварын зардлаас 1.4 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 0.4 сая төгрөгийн нийт 1.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 7 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зааврын хавсралтуудтай тус тус нийцэхгүй байна.

2. Бараа материалын тайланг бэлтгэхдээ орлого, зарлага, шаардах хуудсыг хамтад нь үдсэн нь эмх цэгцгүй ойлгомжгүй байна. Шаардах хуудсанд олгосон зөвшөөрсөн хэсгийг бөглөөгүй. Бараа материалын тайлан, жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогч хянаж гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь НББ тухай хуулийн 13.5.”Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...” гэсэн заалттай нийцэхгүй байна

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 2021 онд нийт 1,556.2 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 172.3 сая төгрөгийн 18 мэдээлэл, орлогын 96.4 сая төгрөгийн 3 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан хэсэгт 179.6 сая төгрөгийн 61 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл хэсэгт 83.7 сая төгрөгийн 4 мэдээлэл нийт 532.0 сая төгрөгийн 86 мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дахь хэсэгтэй нийцэхгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 5.7 сая төгрөгийн 1 алдаа, 1.8 сая төгрөгийн 2 зөрчил, нийт 7.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын хугацаанд 5.7 сая төгрөгийн 1 алдааг залруулж 1.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 532.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Тайлант онд 5.7 сая төгрөгийг татварын байгууллагаас авах авлага, нийгмийн даатгалын байгууллагад төлөх 5.7 сая төгрөгийн өглөгийг бүртгээгүй байсныг аудитын хугацаанд авлага, өглөгөөр бүртгүүлж залруулга хийсэн.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Урсгал засварын зардлаас 1.4 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 0.4 сая төгрөгийн нийт 1.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зааврын хавсралтуудтай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллан урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх.

2. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бараа материалын тайланг бэлтгэхдээ орлого, зарлага, шаардах хуудсыг хамтад нь үдсэн нь эмх цэгцгүй ойлгомжгүй байна. Шаардах хуудсанд олгосон зөвшөөрсөн хэсгийг бөглөөгүй. Бараа материалын тайлан, жолоочийн тооцооны хуудсыг нягтлан бодогч хянаж гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.5."Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно... гэсэн" заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайланг эмх цэгцтэй ойлгомжтой бэлтгэх, анхан шатны баримтыг бүрэн гүйцэт бөглөх, жолоочийн тооцооны хуудсыг хянаж илүү дутууг тооцон ажиллах.

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд нийт 1,556.2 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 172.3 сая төгрөгийн 18 мэдээлэл, орлогын 96.4 сая төгрөгийн 3 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан хэсэгт 179.6 сая төгрөгийн 61 мэдээл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл хэсэгт 83.7 сая төгрөгийн 4 мэдээлэл нийт 532.0 сая төгрөгийн 86 мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дахь хэсэгтэй нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	МХГ <i>Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой</i>	3	7.6	1	5.7					2	1.8
2	МХГ <i>Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой</i>	86	532.0							1	
Дүн		89	539.6	1	5.7					3	1.8



АУДИТЫН ТАЙЛАНГ:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО:



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						<i>Төгрөгөөр</i>
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,141,733,731.04	0.00	1,445,319,041.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,141,733,731.04	0.00	1,445,319,041.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	55,472,198.64	0.00	55,472,198.64
C08	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,197,205,929.68	0.00	1,500,791,240.37
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,197,205,929.68	0.00	1,500,791,240.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,197,205,929.68	0.00	1,500,791,240.37
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-50,752,023.23	0.00	-50,752,023.23
D09	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	244,694,006.84	58,891,303.85	1,146,453,906.45	0.00	1,450,039,217.14